



**БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

Техникийн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 5 дах хэсэг, Байгууллагын 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 3 дах хурлын шийдвэрийг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1. Техникийн зөвлөлийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
2. Техникийн зөвлөлийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн дарга /Г.Пүрэвсүрэн/- д үүрэг болгосугай.

Комиссын дарга

Г. Пүрэвсүрэн /Менежер/

Гишүүд:

М.Бат-Эрдэнэ /Механикч/

Н.Ганболд /Тоног төхөөрөмжийн оператор/

Нарийн бичиг:

Б.Баярцэцэг /Агрономч/


ДАРГА



Г.ГАЛДӨЛ

2150300017

“Бэлчээрийн менежмент-төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт
үйлдвэрийн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн
11/05 дугаар тушаалын хавсралт



ТЕХНИКИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Журмын зорилго, хамрах хүрээ

1.1 Байгууллагын дансанд бүртгэлтэй газар тариалангийн үйл ажиллагаа явуулах зориулалт бүхий машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалтанд хяналт тавих, гарсан эвдрэл гэмтэлд үнэлэлт дүгнэлт өгөхөд энэхүү журмын зорилго оршино.

1.2 Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүх техник, тоног төхөөрөмжүүд бүгд хамаарна.

Хоёр. Баримтлах бодлого

2.1 Байгууллагын хэмжээнд ашиглагдаж байгаа техник, тоног төхөөрөмжинд гарсан:

- Эд ангийн гэмтлийн шинж байдлыг тогтоох;
- Тухайн эд ангид засвар үйлчилгээ хийж ашиглаж болох эсэхийг тогтоох;

Гурав. Зөвлөлийн гишүүдийн үүрэг

3.1 Техникийн зөвлөлийн гишүүн нь тухайн техник, тоног төхөөрөмжинд гарсан гэмтэл, эвдрэлд зөв үнэлэлт дүгнэлт өгөх;

3.2 Техник, тоног төхөөрөмжид гарсан гэмтлийг судалж, үнэн зөв тогтоох;

3.3 Техник, тоног төхөөрөмжийн гэмтэл, эд ангийн эвдрэлд акт баримт үйлдэх, бүртгэл хөтлөх;

Дөрөв. Хэрэглэх маягт

4.1 Ажил мэргэжлийн онцлогт тохирсон маягтыг хэрэглэж, зөвлөлийн гишүүдийн гарын үсгээр баталгаажуулна.

Тав. Гаргах шийдвэр

5.1 Эвдрэл, гэмтэл гарсан тоног төхөөрөмжийн гэмтлийн тогтоож холбогдох саналаа байгууллагын даргад танилцуулж зөвлөлийн шийдвэр гаргана.

5.2 Актлах, солих сэлбэг, хэрэгсэлд дүгнэлт гаргаж акт үйлдэнэ.